БАТЛАВ.

ЦӨМИЙН ЭНЕРГИЙН КОМИССЫН
АЖЛЫН АЛБАНЫ ДАРГА
Г.МАНЛАЙЖАВ

2026 оны 01 дүгээр сарын 12-ны өдөр

# ЦӨМИЙН ЭНЕРГИЙН КОМИССЫН АЖЛЫН АЛБАНЫ 2026 ОНЫ АВЛИГЫН ЭСРЭГ ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ТӨЛӨВЛӨГӨӨ

| д/д | Хэрэгжүүлэх арга хэмжээ | Хугацаа | Гүйцэтгэлийн үзүүлэлт | Хариуцагч |
|---|---|---|---|---|
| Зорилт 1. Авлигын эсрэг хууль тогтоомжийг иргэдэд сурталчлах соён гэгээрүүлэх үйл ажиллагааны хүртээмжийг нэмэгдүүлэх | | | | |
| 1.1 | Авлигатай тэмцэх газраас соён гэгээрүүлэх чиглэлээр бэлтгэсэн контентуудыг а/ байгууллагын албан ёсны цахим хуудас, б/ сошиал сувгууд в/ дотоод сүлжээ г/ хэвлэл мэдээллийг хэрэгсэл, лед дэлгэц е/ бусад (салбар байгууллагууд хэлбэрээр сурталчилж, олон нийтэд хүргэх; | Сар бүр | Авлигатай тэмцэх газраас соён гэгээрүүлэх чиглэлээр бэлтгэсэн контентуудыг дараах дараах сувгаар олон нийтэд хүргэнэ:<br>- www.nea.gov.mn<br>- Цөмийн энергийн комиссын ажлын алба /facebook/<br>- цөмийн нэгдсэн групп /facebook/<br>- байгууллагын дотоод сүлжээ /able/ | Тамгын газар, ЭБАТ |
| 1.2 | Өөрийн байгууллагын үйл ажиллагааны онцлогт тохируулан иргэд, олон нийтэд чиглэсэн соён гэгээрүүлэх нээлттэй хаалганы өдөрлөг, арга хэмжээг зохион байгуулах; | 10 сард | Байгууллагын үйл ажиллагаа ил тод, нээлттэй танилцуулах арга хэмжээ зохион байгуулна.<br>- Авлигатай тэмцэх газраас өрнүүлж буй аян, уриалгатай уялдсан байх;<br>- Үр дүнг тооцсон байх. | Ажлын алба, ЭБАТ |

| | | | | |
|---|---|---|---|---|
| 1.3 | Өөрийн байгууллагын эрх хэмжээ, үйл ажиллагаатай холбогдуулан эрхлэн гаргадаг ном гарын авлага, сэтгүүл, иргэдэд тараадаг хэвлэмэл материал зэрэгт авлигын хор хөнөөлийг иргэдэд ойлгуулах, шүгэл үлээхийг сурталчлан таниулсан, түүнд уриалсан мэдээлэл болон авлигын мэдээлэх 110 дугаарыг оруулан сурталчлах; | 3 сард | - Мэдээллийг Авлигатай тэмцэх газраас буюу баталгаат эх сурвалжаас авсан байх;<br>- Байгууллагын эрх хэмжээний хүрээнд иргэд, олон нийт рүү чиглэсэн хэвлэмэл материалд оруулсан байх; | Ажлын алба, ЭБАТ |
| 1.4 | Өөрсдийн байгууллагын үйл ажиллагаанд авлигад өртөж болзошгүй чиглэлийг сонгон авлигын эрсдлээс ангид байхад чиглэсэн, ёс зүй, шударга байдлыг уриалсан агуулга бүхий 2-оос доошгүй видео контент бүтээж олон нийтэд хүргэсэн байх; | Жилдээ | - Авлигын эрсдлээс урьдчилан сэргийлэхэд чиглэсэн байх;<br>- Авлигын мэдээлэх 110 дугаарын утсыг сурталчилсан байх;<br>- Олон нийтэд түгээсэн байх; | Ажлын алба, ЭБАТ |
| Зорилт 2. Ил тод байдлыг сайжруулах, хүнд суртал, чирэгдлийн бууруулах, олон нийтийн хяналтыг хэрэгжүүлэх | | | | |
| 2.1 | "Төрийн байгууллага, албан тушаалтны үйл ажиллагаанд олон нийтийн хяналтыг хэрэгжүүлэх журам"-ыг хэрэгжүүлэх; | 5 сард | - Журамд заасны дагуу өөрийн байгууллагын үйл ажиллагааны 1-ээс доошгүй чиглэлд олон нийтийн хяналтыг хэрэгжүүлэхээр сонгосон байх;<br>- Сонгосон чиглэлд олон нийтийг хяналтыг хэрэгжүүлэх сонгон шалгаруулалт зарласан байх;<br>- Олон нийтийн хяналтыг хэрэгжүүлэн тайлганах;<br>- Үр дүнд суурилсан арга хэмжээг зохион байгуулсан байх. | Тамгын газар, ЭБАТ |
| 2.2 | Авлигаас урьдчилан сэргийлэх, соён гэгээрүүлэх үйл ажиллагаанд иргэний нийгмийн оролцоо, хамтын ажиллагааг нэмэгдүүлэх; | 6 сард | - Салбарт бүрт үйл ажиллагаа явуулж буй төрийн бус байгууллагуудын нэгдсэн судалгааг гаргасан байх;<br>- Авлигаас урьдчилан сэргийлэх, соён гэгээрүүлэх чиглэлээр иргэний нийгмийн оролцоо, хамтын ажиллагааг нэмэгдүүлэх чиглэлээр арга хэмжээ авсан байх; | Ажлын алба, ЭБАТ |

| | | | | |
|---|---|---|---|---|
| 2.3 | Хөрөнгө оруулалтын төсөл, арга хэмжээний төлөвлөлт, хэрэгжилтийн талаарх мэдээллийн нээлттэй, ил тод байдлыг нэмэгдүүлэх; | Тухай бүр | - Хөрөнгө оруулалтын төсөл, арга хэмжээний хэрэгжилтийн талаар иргэд, олон нийтэд ойлгомжтой байдлаар тогтмол мэдээлэх; | Ажлын алба, ЭБАТ |
| 2.4 | Байгууллагын үйл ажиллагаа, үйлчилгээний хүнд суртал чирэгдэлтэй холбоотой ирүүлсэн гомдол, мэдээлэлд дүн шинжилгээ хийж үр дүнд суурилсан арга хэмжээг хэрэгжүүлж хэвших; | Тухай бүр | - Хуулийн хүрээнд шуурхай, бодитой шийдвэрлэж хэвших;<br>- Иргэд, олон нийтээс байгууллагын үйл ажиллагаа, хүнд суртал чирэгдэл, холбоотой гомдол мэдээлэлд дүн шинжилгээ хийж, үр дүнд суурилсан арга хэмжээг хэрэгжүүлэх. | Тамгын газар, ЭБАТ |
| Зорилт 3. Авлига ашиг сонирхлын зөрчил үүсгэх шалтгаан, нөхцөлийг арилгуулах арга хэмжээ авах | | | | |
| 3.1 | Авлигын эсдэл ба авлига гарах боломжийг бууруулах чиглэлээр тухайн байгууллагаас цахимаар иргэд, олон нийтэд үзүүлж буй цахим үйлчилгээний чанар хүртээмжийг дээшлүүлэх чиглэлээр арга хэмжээг зохион байгуулах | 6 сар, 12 сард | - Байгууллагын office@nea.gov.mn цахим шуудантд ирж буй санал гомдлыг судлах, дүн шинжилгээ хийж, үйлчилгээг сайжруулах арга хэмжээ авах;<br>- Зөвшөөрийн хүсэлт хүлээн авч шийдвэрлэх Igov.mn болон бусад холбогдох цахим хуудсуудаар үзүүлж буй үйлчилгээний чанар хүртээмжийг дээшлүүлэх. | Ажлын алба, ЭБАТ |
| 3.2 | Байгууллагын дотоод хяналтын механизмыг сайжруулж, алба хаагчдыг авлига, ашиг сонирхлоос ангид байхад чиглэсэн арга хэмжээг хэрэгжүүлэх; | Тухай бүр | - Албан хаагчидтай холбогдуулан ирүүлсэн авлига, ашиг сонирхлын зөрчилтэй холбоотой гомдол, мэдээллийг Авлигатай тэмцэх газарт шилжүүлж хэвших.<br>- Албан хаагчдыг авлига, ашиг сонирхлын зөрчлөөс ангид байхад чиглэсэн арга хэмжээг байгууллагын үйл ажиллагааны онцлогт тохируулан эрсдэлийг тодорхойлсон байх;<br>- Эрсдэлийг арилгах арга хэмжээнд дотоод хяналтын үйл ажиллагааг зохион байгуулсан байх; | Тамгын газар, ЭБАТ |

| | | | | |
|---|---|---|---|---|
| 3.3 | Тухайн байгууллага өөрийн үйл ажиллагааны онцлогт тохируулсан авлигаас урьдчилан сэргийлэх, соён гэгээрүүлэх чиглэлээр шинээр санал, санаачилга гарган тодорхой арга хэмжээг хэрэгжүүлэх; | 5 сар, 10 сард | - Нийтээр дагаж мөрдөх хэм хэмжээний актыг төслийг цахим хуудасд байршуулж, олон нийтийн саналыг авах;<br>- Цацрагийн хамгаалалт, аюулгүй ажиллагаа, аюулгүй байдлыг хангахтай холбоотой батлагдсан дүрэм, журмыг байгууллагын цахим хуудасд байршуулах. | Ажлын алба, ЭБАТ |
| Бусад арга хэмжээ | | | | |
| 4.1 | Байгууллагын удирдлага, газар, хэлтэс авлигатай тэмцэх чиглэлээр харилцан уялдаатай, хамтран ажиллах | 1 сард | Авлигын эсрэг соён гэгээрүүлэх, авлигатай тэмцэх, урьдчилан сэргийлэх арга хэмжээний төлөвлөгөөг хэрэгжүүлэн ажиллаж, байгууллагын төлөвлөгөөнд тусгах | Удирдлага, газар, нэгжүүд |
| 4.2 | Авлигын эсрэг соён гэгээрүүлэх, авлигатай тэмцэх, урьдчилан сэргийлэх арга хэмжээний тайлан гаргаж, дүгнэх | 6 сарын 30, 12 сарын 15 | Khutulbur.iaac.mn цахим хуудасд тайланг оруулж, дүгнэх | ЭБАТ |

ХЯНАСАН.

ТАМГЫН ГАЗРЫН ДАРГА Б.БААТАРЦОГТ

БОЛОВСРУУЛСАН:

ЦӨМИЙН АЮУЛГҮЙ БАЙДЛЫН БОДЛОГЫН ГАЗАРЫН ДАРГА,
ЭРХ БҮХИЙ АЛБАН ТУШААЛТАН Э.НЯМДАВАА